



МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБООНЫ БАРИМТЛАЛ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛ - АЛСЫН ХАРАА

Монгол Улсад аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх алсын харааг судалгааны үндэслэлтэйгээр томёолвол “Аялал жуулчлалын салбарын үр нөлөөгөөр байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах замаар, хүн төрөлхтний хийгээд үндэсний үнэт зүйлсийг эрхэмлэн баталгаажуулагч, бүтээгч “Монгол хүн”-ийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино”.

Хөгжлийн үндсэн зарчим:

- Бид нэгэн сэтгэлээр, нэгдэн хөдөлж, эв зөийг батжуулах нь хөгжлийн суурь зарчим мөн.

Үнэт зүйл:

- Монгол хүн, байгаль, соёл, хувийн хэвшил, хэрэглэгч

Хөгжлийн хараа:

- Дэлхийн зах зээл дээрх тусгай сонирхлын аяллын олон янз бүтээгдэхүүнийг улирлаас үл хамааран хангасан, үнэ цэнтэй зорих газар байна. Монгол Улсын экспортын тэргүүлэгч салбар болно.

Салбарын тулгуур багана:

- Хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчин
- Мэрэгжлийн өрсөлдөх чадвар бүхий компани байгуулагууд
- Орон нутгийн иргэд, малчид
- Төр засаг, институт
- Жуулчид
- Өртөг үйлдвэрлэгч, хамтрагчид

Салбарын хөгжлийн чиглэл:

Нутгийн брэндийг нийслэлд, нийслэл нутгийн брэндийг дэлхийд холбох гүүр болж Хөрөнгө оруулалт, ЖДҮ, улс орны сурталчилгаа, соёлын үйлдвэрлэл, зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлэгч, ногоон хэрэглээ, тойрог эдийн засгийн (Circular economy), хотын хөгжил, цахим хэрэглээний бодит хэрэглээг хүргэгч салбар байна

МАЖХ-ны эрхэм зорилго нь Монголын аялал жуулчлалын салбар дахь бүх оролцогчдыг төлөөлсөн дээвэр байгууллага байж гишүүдийнхээ нийтлэг эрх ашиг сонирхлыг хамгаалан, аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийг холбож ажиллахад оршино.

МАЖХ-ны үнэт баялаг:

Аялал жуулчлалын хувийн хэвшил, баялаг бүтээгчид, Холбооны гишүүд, дэмжигчид

МАЖХ-ны зарчим: Төр ба хувийн хэвшлийн оновчтой менежментийг хадгалж, нэгдмэл удирдлага зохицуулалтаар хангахад чиглэнэ. Хувийн хэвшлийн бизнесийн тогтвортой, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахын төлөө ажиллахад оршино.

Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх үндсэн стратегийг дараах байдлаар тодорхойлж байна. **Үүнд:**

- Зорих газрын оновчтой засаглал ба институцийн тогтолцоог сайжруулах,
- Тогтвортой аялал жуулчлалыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах зарчмаар хөгжүүлэх,
- Аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх үндэсний маркетингийг бий болгох,
- Зорих газрын менежмент, дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг өрсөлдөхүйц болгон хөгжүүлэх
- Монгол улсын аялал жуулчлалыг гадаад улсад сурталчлан танилцуулах, маркетингийн идэвхижүүлэлтийг зорилтот зах зээлд тогтмолжуулах зэрэг болно.

Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын шалгуурыг шинэчлэн өөрийн орны онцлог дэлхий нийтийн чиг хадлагатай хослуулан хөгжлийн хөтөч болгон хөгжүүлэхийг эрхэмлэнэ. Тухайлбал, тогтвортой аялал жуулчлалын байгаль, нийгэм, эдийн засгийн тулгуур хүчин зүйл, шалгуурыг 1/ Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, 2/ Соёлын өвийг хадгалан хамгаалах, 3/ Орон нутгийн иргэдэд үзүүлэх нийгэм, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, 4/ Урт хугацааны тогтвортой байдлыг хангах зэргээр хэрэгжүүлнэ. **Үүнд:**

1. Эдийн засгийн чадвар. Урт хугацаанд үр ашигтай, тасралтгүй оршин тогтнохын тулд жуулчдын зорин очих газар болон бизнесийн өрсөлдөх чадварыг хангах.
2. Хөдөлмөр эрхлэлтийн чанар. Аялал жуулчлалын тусламжтайгаар орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлж, чанарыг сайжруулан төлбөрийн хэмжээ, үйлчилгээний нөхцөл, ажил эрхлэлтийн хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх.
3. Жуулчны сэтгэл ханамж. Жуулчдыг нас, хүйс, гарал угсаагаар үл ялгаварлан тэдний аюулгүй байдлыг ханган, сэтгэл ханамжтай байлгах.

4. Нутгийн иргэдийн амьжиргаа. Орон нутгийн иргэдийн тохь тухтай амьдрал, нөөцийн хэрэглээг дэмжих байдлаар амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгмийн доройтлоос ангижрах.
5. Бүрэн бүтэн байдал. Хот суурин газар болон хөдөө орон нутгийн газар нутгийг хамгаалах, байгаль орчны доройтлоос сэргийлэх.
6. Нөөцийн үр ашиг. Аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхийн тулд дахин сэргээгдэхгүй нөөцийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах.
7. Орон нутгийн хөгжил. Аялал жуулчлалын тухайн бүс нутгийн ирээдүйн хөгжил, удирдлагын шийдвэр гаргалт, төлөвлөлтөд орон нутгийн иргэдийг оролцуулах.
8. Нийгмийн тэгш байдал. Жуулчдаас ирэх нийгэм, эдийн засгийн үр нөлөөг тэлэх, ядуурлыг бууруулахад тодорхой хэсгийг хуваарилах.
9. Орон нутгийн хяналт. Аялал жуулчлалын тухайн бүс нутгийн ирээдүйн хөгжил, удирдлагын шийдвэр гаргалт, төлөвлөлтөд нутгийн иргэдийн оролцуулах.
10. Соёлын өв. Нутгийн уугуул иргэдийн өвөрмөц түүхэн соёл, өв уламжлал, зан заншлыг хүндэтгэх.
11. Биологийн төрөл зүйл. Байгаль орчин, зэрлэг ан амьтдын амьдрах орчны хамгаалалт, тэдэнд учирч болзошгүй аюулыг багасгахад дэмжлэг үзүүлэх.
12. Байгаль орчны цэвэр байдал. Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид болон жуулчдын үүсгэсэн хог хаягдал, ус, агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Аялал жуулчлалын салбарыг доорх гурван үндсэн чиглэлээр хөгжүүлэхийг МАЖХ-ны үндсэн зарчим гэж үзнэ. **Үүнд:**

1. Амралт чөлөөт цагийн аялал жуулчлал
2. Бизнес, ажил хэргийн буюу MICE аялал жуулчлал
3. Эрүүл мэнд, боловсролын буюу тухайн салбарын тусгай аялал жуулчлалын хөгжил тус тус болно.

Аялал жуулчлалын үйлчилгээний нийлүүлэлтийг цаашид дараах хүчин зүйлсийг анхааран хөгжүүлэх хэрэгтэй. **Үүнд:**

Оролцогч талуудын хамтын ажиллагаа. Аялал жуулчлалын шинэ чиглэлүүдийг хөгжүүлэх, стандарт баталгаат бус барилгын үйл ажиллагааг хянан тооцох, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн, иогийн, органик, бясалгалын, адал явдлын, соёл сэргээх, шашны, сайн дурын-волентуризмын зэрэг сэдэвчилсэн аяллуудыг сурталчлах, явуулах заавар дүрэм, ёсзүйн код зэргийг боловсруулах

Аялал жуулчлалын бүсчлэл. Байгалийн онцгой, эмзэг бүс нутаг руу нэвтрэх үед жуулчдад тодорхой хязгаарлалтуудыг тавих, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтын менежментийн гэрээг байгуулж ажиллах, чадавхжуулах,

Хог хаягдал бохирдлын менежмент. Хог хаягдал нь байгаль орчин, зэрлэг амьтдад сөрөг нөлөө үзүүлэхийг зэрэгцээ орчны гоо зүйн үнэ цэнийг унагаадаг тул хог хаягдалд хяналт тавих үүрэгтэй холбогдох албаны хүмүүст аливаа зөрчлийн талаар цаг алдалгүй анхааруулдаг мэдээллийн технологийн шийдлүүд хэрэгтэй.

Эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын зохицуулалт. Коронавируст халдвараас үүссэн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг тэргүүн зэрэгт тавьж, ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг нарийвчлан тодорхойлж, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй газруудад мөрдүүлэх нь зүйтэй. Тухайлбал, амьдрах орчин, гал тогоог ариутгах, органик хүнсээр хоол бэлтгэх, хоол хүнс бэлтгэх орчныг нийтэд ил тод байлгах, анхан шатны тусламж, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх сургалт зохион байгуулах, бүрэн автоматжуулсан ариун цэврийн өрөө байгуулах гэх мэт. Энэ нь эцсийн дүндээ бүтээгдэхүүний нийлүүлэлтийн өртгийг нэмэгдүүлнэ.

Ухаалаг хэрэглээ. Цахим болон технологийн хэрэглээ, мэдээлэл, харилцаа, захиалга, санал хүсэлт, эрэлт нийлүүлэлтийн менежментийг шинээр өөрчилж буйтай нийцэн зохицох хэрэгтэй. Жуулчид байгаль орчныг хамгаалах, орон нутгийн онцлогийг хүндэтгэн үзэх, орчны үнэлгээ, нөхцөлдөө гар утас, аппликэйшн, төрөл бүрийн системтэйгээр мэдээлдэг, оролцдог боломжийг хангах ёстой. Улмаар аялал жуулчлалын бүс нутгийг цахимжуулж, цааснаас ангид болгох, хоол хүнсийг зайнаас хүргэх, газар нутгийг хаягжуулах зэрэг үйл ажиллагаа болон хог хаягдлын менежментэд орчин үеийн технологийг ашиглах нь хөгжлийг олон алхмуудын нэг юм.

Үнийн хэт өсөлт ба инфляцын тогтворжуулалт. Урт хугацаандаа тогтвортой хийгээд дэвшилттэй (progressive) уян хатан байдлыг ханган бэхжүүлэх, ашиг орлогыг илүү шударгаар орон нутагт нь шууд хуваарилах өртгийн сүлжээ чухал байна.

Мэргэжлийн боловсон хүчин. Хүний нөөцийн бодлогыг мэргэжлийн ажилтнууд, салбар дундын боловсон хүчин, стратегийн боловсон хүчний дунд буюу яамд хооронд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаан дунд хөгжүүлэхэд оршино.

Салбарын болон салбар дундын хамтын ажиллагаа. Судалгаан дээр үндэслэсэн бодит өгөөж, аялал жуулчлалын компаниудын эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагааг идэвхжүүлэн, оролцогч талуудыг манлайлан идэвхжүүлэх зэрэг болно.